

*Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 12-р сарын 29-ны өдрийн 629 тоот тушаалын Хавсралт*

**БАНКИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.Банкны тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу банкнийг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, түүнд Монголбанкнаас зөвшөөрөл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2.Банкийг өөрчлөн байгуулахад Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

3.Албадлагын арга хэмжээний хүрээнд банкнийг Монголбанкны шийдвэрээр өөрчлөн байгуулах ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

4.Банкийг өөрчлөн байгуулах гэдэг нь Компанийн тухай хуулийн дагуу банк нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах болон банкны хэлбэрийг өөрчлөх үйл ажиллагааг хэлнэ.

5.Хоёр буюу хэд хэдэн банкуудын үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг хариуцлагыг шинээр үүсэн байгуулагдах банкинд шилжүүлэхийг банкууд нийлэх /merger/ гэнэ.

6.Банкны үйл ажиллагааг зогсоож, түүний эрх үүрэг, хариуцлагыг үйл ажиллагаагаа явуулж буй өөр банкинд шилжүүлэхийг банк нэгдэх /acquisition/ гэнэ.

7.Банкны үйл ажиллагааг зогсоож, түүний эрх үүргийг ялган зааглаж шинээр үүсэн байгуулагдах банкуудад бүрэн шилжүүлэхийг банкнийг хуваах /demerger/ гэнэ.

8.Банкны үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим хөрөнгө, эрх, үүргийг шинээр үүсэн байгуулагдах банкинд шилжүүлэхийг банкнийг тусгаарлах /segregation/ гэнэ.

9.Банкийг хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээс хувьцаат хэлбэрт, хувьцаат хэлбэрээс хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрт шилжүүлэхийг банкны

хэлбэрийг өөрчлөх /change the type of company/ гэнэ.

10.Банк нь өөрчлөн байгуулалт хийхдээ Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 4, 5, 6, 7, 8 дугаар зүйлүүдэд заасан заалтыг мөрдлөг болгоно.

11.Хуульд заасан тохиолдолд шүүх Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу банкийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

12.Өөрчлөн байгуулагдаж, Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан банкинд бусад банкуудын нэгэн адил шаардлага, хяналт тавина.

### **ХОЁР. Банкнийг өөрчлөн байгуулахад Монголбанкнаас зөвшөөрөл олгох**

1.Банкны ТУЗ нь өөрчлөн байгуулах хэлбэрээс хамааруулан энэ журмын хавсралтад заасан бичиг баримтыг бүрдүүлж, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан Монголбанкны Хяналт шалгалтын газар /цаашид ХШГ гэх/-т ирүүлнэ.

2.ХШГ нь банкийг өөрчлөн байгуулах бичиг баримтыг хүлээж аваад шаардлагатай гэж үзвэл нэмэлт материалыг шаардаж болно. Нэмэлт материал бүрдүүлж өгсөн өдрийг өөрчлөн байгуулах тухай өргөдөл гаргасан өдрөөр тооцно.

3.Монголбанк банкийг өөрчлөн байгуулах өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэж, шаардлагатай гэж үзвэл нийтэд мэдээлнэ.

4.Банкийг өөрчлөн байгуулах тухай бичиг баримтад дараахь шаардлагыг тавина:

1/Бичиг баримтын бүрдэлт бүрдүүлбэр нь бүрэн гүйцэд, үнэн зөв, алдаагүй байх;

2/Энэ журмын хавсралтад заасан бичиг баримт нь эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувь байх;

3/санхүүгийн тайлан болон бусад тайланг үнэн зөв гаргасан эсэхийг нотолсон удирдлага /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал/-ын гарын үсэг бүхий тодорхойлолт байгаа эсэх.

5.ХШГ нь баримт бичгүүдийг энэхүү журам болон "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ын дагуу шаардлага хангасан эсэх, өөрчлөн

байгуулах үйл ажиллагааны үр дүнд үүсэх банкууд нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжтой эсэх, өөрчлөн байгуулах үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянана.

6.Банкны өөрчлөн байгуулах хүсэлт, холбогдох бичиг баримт нь хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд Хуулийн хэлтэс санал дүгнэлт гаргана.

7.Шаардлагатай гэж үзвэл ХШГ өөрчлөн байгуулалт хийгдэх банкны үйл ажиллагааг газар дээр нь очиж шалгана.

8.Монголбанк дараахь тохиолдолд банкиг өөрчлөн байгуулахад зөвшөөрөл олгохоос татгалзана:

1/Өөрчлөн байгуулах зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримт энэ журамд заасан шаардлага хангаагүй;

2/Банкийг өөрчлөн байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал;

3/Хуваах, тусгаарласны үр дүнд үүссэн банкуудын дүрмийн сан, өөрийн хөрөнгийн хүрэлцээ нь хуульд тогтоомжоор тогтоосон доод хэмжээг хангаагүй;

4/Өөрчлөн байгуулалтын үр дүнд зах зээлийн өрсөлдөөнийг бууруулах, цаашид хязгаарлах зэрэг сөрөг үр дагавар бий болгохоор байвал;

5/Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.ХШГ нь өөрчлөн байгуулах бичиг баримтыг энэхүү журамд заасан шаардлага хангасан байна гэж үзвэл санал дүгнэлтээ боловсруулж, Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

10.Өөрчлөн байгуулагдсан банк нь өөрчлөн байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор тайлангаа ХШГ-т ирүүлнэ.

### **ГУРАВ. Хариуцлага**

1.Банкийг өөрчлөн байгуулах үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд тухайн банкны удирдлага, холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.